



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/236

Хэрлэн сум

Батлан хамгаалах газар, цугларах,  
шилжүүлэх байрыг томилгоожуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Дайчилгааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2020 оны н/203 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн дайчилгааны заавар”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн дайчилгаа зарласан үед Батлан хамгаалах газрын байрыг аймгийн Засаг даргын Тамгын газрын 2 давхарт, цугларах байрыг Политехник коллежийн хичээлийн байранд, шилжүүлэх байрыг Авто тээврийн төвийн байранд дэлгэхээр томилгоожуулсугай.

2.Батлан хамгаалах газар, цугларах, шилжүүлэх байранд ажиллах албан тушаалтнуудыг 1 дүгээр хавсралтаар, ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар, байрын бүдүүвчийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Батлан хамгаалах газар, цугларах, шилжүүлэх байрын бүрэлдэхүүнийг томилгоожуулан, тогтоосон хугацаанд тодотгож, сургалт, дадлагыг тогтоосон журмын дагуу явуулж байхыг Цэргийн штабын дарга хурандаа Н.Хүрэлээ, цугларах байрын дарга Б.Болд-Эрдэнэ, шилжүүлэх байрын дарга Ц.Бат-Эрдэнэ нарт тус тус даалгасугай.

4.Батлан хамгаалах газар, цугларах, шилжүүлэх байрын бичиг баримт, техник хэрэгслийг бүрдүүлж, хээрийн нөхцөлд дэлгэх бэлтгэлийг хангасугай.

5.Цагийн байдлаас шалтгаалан Батлан хамгаалах газар, цугларах, шилжүүлэх байрыг өөрчлөх шаардлага, гарвал Мөрөн суманд шилжүүлэн зохион байгуулах бэлтгэл хангахыг Цэргийн штабын дарга (хурандаа Н.Хүрэлээ), Мөрөн сумын Засаг дарга (Ц.Батцоож)-д тус тус үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ